

Манж Чин улсаас Өвөр Монголын бэлчээр нутгийг
хагалбарлахад авсан бодлогын тухай

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Хөгжил
/Өвөр Монгол. БИС/

Тэнгэрийн сэцэний 8 дугаар он /1634/ онд манжийн ноёрхогчдоос Өвөр Монголыг эзлэн авсны хойно хошуу чуулганы дүрмээр монголчуудыг зохион байгуулалт тус тусад нь салган захирсанаар барахгүй, дараа нь бас боомтын дотроос хятад тариачдыг элсүүлэн авчирч, алхам алхмаар бэлчээр нутгийг хагалбарлан тариалах төрийн бодлогыг хэрэгжүүлсэн байжээ.

Тэгэхдээ энэхүү төрийн бодлогоо бодитой хэрэгжүүлэх явцад дорхи хэдэн шат үеийг дамжсан юм.

Нэгдүгээр шат үеийг эээр засагчийн анхдугаар он /1644/ оноос тэнгэр тэтгэгчийн 13 дугаар он /1748 он/ болно.

Энэхүү цаг хугацаанд Чин улсын засгийн газраас хэдийгээр бэлчээр нутгийг хагалбарлан тариалахыг цаазлан хориглох дүрэм тогтоолуудыг нийтэлсэн боловч бодит хэрэг дээрээ зарим нөхцөл байдалд хятад тариачид монгол газар ирж бэлчээрийг хагалбарлан тариалахыг дахин зөвшөөрөх бодлогыг явуулж байсан юм. Эээр засагчийн эхний жилүүдэд манжийн ноёрхогчдоос бас: "Боомтын дотор байгаа хил хязгаарын сул уудам газар оронд цэрэг суулган тариалуулж, боомтын гадна байгаа бэлчээрийн газрыг хагалбарлан тарихыг хоригломой"¹ гэсэн тогтоолыг гаргасан боловч тэнгэр тэтгэгчийн 13 он /1748 он/-оос өмнө энэхүү дүрэм тогтоолоо ер нь сайтар хэрэгжүүлээгүй юм. Чин улсын эхэнд ноёрхолоо бэхжүүлж, үйлдвэрлэлээ сэргээж, аж ахуйгаа хөгжүүлэхийн төлөө Өвөр Монголд нэг талаар монголчууд өөрсдөө тариалан эрхэлж, аму хүнсний хэрэгцээгээ шийдвэрлэхийг хөхүүлж байсан² бөгөөд нөгөө талаар боомтын доторхи хятад иргэд Монгол газар ирж, бэлчээр хагалбарлан тариалахыг хориглох боловч зарим байдлын дор дахин зөвшөөрөх бодлогыг авч Ёстын чуулган зэрэг оронд жил бүр 800 хятад тариачин монгол оронд ирэхийг зөвшөөрсөн замын гэрч бичгийг өрхийн журганаас олгож байжээ.³ Энэ мэтээр эээр засагч Энх-Амгалан Энэрэлт төвийн үеэс Манжийн засгийн газраас нилээд чөлөөтэй төрийн бодлогыг хэрэгжүүлснээс боомтын дотроос Өвөр монголд ирсэн хятад тариачид өдөр ирэхүйяа олширч, Энх-Амгалангийн 51 дүгээр он /1912 он/ болоход "зөвхөн Шандунь мужаас ӨвөрМонголд ирж тариаланчид даруй зуун мянган иргэн байжээ."⁴ Энэхүү байдал тэнгэр тэтгэгчийн эхний үес болоход улмаар хүнд ноцтой болсон бөгөөд Хөх хотын түмэн орны монголчуудын бэлчээр нутгийн олонхи нь бүр хятад тариачдад эзэмшигдсэн болохоор засгийн газраас арга бус /буюу/ зарлиг буулган, газар нутгийг монгол өрхөд буцаан авч өгч байсан юм.⁵

Дотор орны хятад тариачид бүлэг бүлгээр боомтыг даван монгол оронд ирээд эхэндээ хятад айл тосгон болж бүрэлдэн суурьшиж, дараа нь хятад иргэдээс монгол айл хотод холилдон суурьшиж, монгол айл хотод хятад нь олон, монгол өрхийг шахан явуулах болжээ. Түүнчлэн хятад тариачид цагаан хэрэм дагуу дахь Монгол нутаг тариалж байснаа удалгүй цул малжих орны зүг урсан тархсан юм.

Хоёрдугаар шат нь тэнгэр тэтгэгчийн 13 дугаар он /1748 он/-оос 60 дугаар он /1795 он/ болно. Энэхүү цаг үед Манж чин улсын ноёрхол нэгэнт бат бэх болж, аж ахуйн талаар асар хөгжилтэй болсон тул боомтын доторхи хятад иргэд Өвөрмонголд нүүдэллэн орох буюу монгол оронд нэгэнт суурьшсан хятад тариачдад зориулан тэнгэр

¹ "Чин улсын түүхэн ноорог"-ийн 120 дугаар ботийн "Аму барааны 1 дүгээр бүлэг"

² /Чин/ "Шию фин хао бичгийн өргөнөө туурвисан газрын зургийн цуврал бичиг"-ийн нэгдүгээр дугуй дахь "Суй Луан Жихэ бичиг"

³ "Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хуулийн хөрөг зүйлийн бичиг"-ийн 742 дугаар боть

⁴ Дайчин улсын шаанчи хооны магад хууль-ийн 25 дугаар боть. "Энх амгалангийн 51 дүгээр оны I сарын гэрээ. Барс өдрийн зурвас"

⁵ "Өвөр Монголын зүүн түмэд хошууны түүхийн данс материал" дахь "Чин улс, газар нутаг"

тэтгэгчийн 13 он, 14 он хийгээд 39 онд тус тусыг зурвас цаазлан хориглох дүрэм тогтоолуудыг нийтэлсэн бөгөд эдгээр дүрэм тогтоолыг хойшдын төрийн ноёрхогчдоос Өвөр Монгол дахь монгол ба хятадын хоорондох газрын маргаан буюу малжих ба тариалах харьцааг шийдвэрлэх ерөнхий төрийн бодлого нь болсон юм.

Энэхүү төрийн бодлогын гол агуулга нь "Монгол газар зөвшөөрөлгүйгээр нүүж ирсэн хятад иргэдийг уг нутагт нь албадлагаар буцаан шинээр хагалбарлан тарих буюу монгол өрхийн газар нутгийг хятад тариачдад хөлсөөн өгөхийг цаазлан хориглож, энэхүү тогтоолыг зөрчсөн хятад иргэн буюу монгол хошуудыг засаг ноёд, монгол малчдыг тус тусд нь залхаан шийтгэнэ. Монгол оронд нэвтрэх аливаа хаалга замд харуулын цэрэг суулгаж, боомтын доторхи хятад тариачид монгол оронд нэвтрэн орохыг хориглоно"⁶ гэх мэтийн зүйлүүд байна.

Тэнгэр тэтгэгчийн үеэс тогтоосон боомтын доторхи хятад иргэд Өвөр Монголд их хэмжээгээр нүүдэллэн орохыг хориглон цаазлах, бэлчээр нутгийг хагалбарлан тархиыг хориглон зогсоох зэрэг төрийн бодлого нь тухайн үед мөн ч сайтар явагдаж чадахгүй байжээ. Үүний шалтгаан нь:

Нэгдүгээрт: Өвөр Монголд орж ирсэн хятад тариачид нь чуулган ба хошуу нутгуудад урсан орсны дараа тэндэх нийгмийн үйлдвэрлэлийн голлогч хөдөлмөрийн хүчин болсон юм. Монголын феодал ван ноёдоос эдгээр тариачдыг хөлслөн дайчилж өөрсдийн харъяат газар нутаг дээрээ тариалан эрхлүүлж, маш их ашиг хонжвор олж байжээ.

Хоёрдугаарт: Монгол оронд ирсэн боомтын доторхи хятад иргэдийн олонхи нь ядуу зүдүү ард түмэн болох тул тэднүүс уг нутагт нь хөөн хариулбал газар, тариа, хөрөнгө хогшил юу ч үгүй болж амьдрах аргагүй болох үес хамтран босолцож хэрэг үймээн үүдэх аюултай байжээ.

Гуравдугаарт: Өвөр Монголын олонхи газарт монгол хийгээд хятадын хооронд аж ахуйн талаар маш нягт харьцаатай болжээ. Хятадын газрын эзэн буюу баян худалдаачид газар тариа худалдан авч пүүс дэлгүүр эрхлээд он удсан тул монголын феодал ван ноёд буюу малчин ардтай аж ахуйн харьцаа үүсч тариан түрээс ба өр зээллэгийн нягт харилцаатай болжээ.⁷ Энэхүү байдлын дор Чин улсын засгийн газраас Монгол оронд ирсэн хятад иргэдийн тухай төрийн бодлоготоо хөсөг хэмжээний тохируулалт хийсэн байжээ.

Гуравдугаар шат нь Сайшаал-ерөөлтийн анхны он /1796/ оноос Бадаргуулт төрийн 29 дүгээр он /1901/ оны хооронд болно.

Энэхүү цаг үед Чин улсын засгийн газраас Өвөрмонголын бэлчээр нутгийг өргөтгөн хагалбарлахыг цаазлан хориглохын дагуу бас зарим газар оронд жишээлбэл Бүгд захирах хошуу зэрэг шууд эзэмшлийн оронд иргэдийг элсэн бэлчээрийг хагалбарлан тариалах бодлогыг хэрэгжүүлжээ.

Үүнд дорхи 3 зурвас дүрэм тогтоолыг хэрэгжүүлсэн байна.

Нэгдүгээрт. Монгол оронд хятад тариачдаас нэгэнт хагалбарлаж эзэмшсэн тариан газрыг тохин мэдрэх бөгөөд иргэдээс бэлчээр нутгийг хувиараа өргөтгөн хагалбарлахыг чанга хориглоно.

Хоёрдугаарт: Дүрэм тогтоолыг зөрчиж, хувийн талаас бэлчээр нутгийг үргэлжлэн хагалбарлан тариачдыг чанаар залхаан шийтгэнэ.

Гуравдугаарт: Монголчуудын мал аж ахуйн үйлдвэрлэлийг нөлөөлөхгүй байдлын дор орон нутгийн албан яамны зөвшөөрөлтэйгээр зарим монгол хошуу /Бүгд захирах хошуу малжилын найман хошуу/-нуудын сэл бэлчээрийн газарт албанаас иргэдийг элсэн атар хагалбарлаж тариалахыг зөвшөөрнө. Гэвч эдгээр дүрэм тогтоол нь монгол газар хятад иргэд нэмэгдэхийг хориглож чадахгүй байлаа.

⁶ "Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хуулийн хөрөг зүйлийн бичиг"-ийн 742 дугаар боть

⁷ Бээжин төвийн данс эвхмэлийн товчооны Мин улс, Чин улсын архивын хэлтсийн хадгаламж "Улаан бийрээр баталсан бодрол бичиг, иргэдийн хэрэг зүйл"

Жирмийн чуулганы Хорчин зүүн гарын өмнөд хошуу хийгээд дундад хошууны байдлаас үзэхэд: Төр гэрэлтийн 2 дугаар онд хоёр хошууд 200 гаруй өрх хятад иргэн суурьшин бараг 2000 гектар бэлчээрийг хагалбарласан байна. Төр гэрэлтийн 3 дугаар онд тус хоёр хошуунд хятад иргэн нэмэгдээд 353 өрх болж, хагалбарласан бэлчээрийн газар нь 4730 гектарт хүрчээ.⁸

Өвөр монголын бэлчээр нутаг үргэлжлэн их хэмжээгээр хагалбарлагдаж байгаа байдлын өмнө Чин улсын засгийн газраас нэг талаар Монгол ван ноёдыг сэрэмжлүүлэн шийтгэх бодлогыг авч Сайшаал өрөөлтийн 11 онд: "Эл засаг жич сул ван гүн нар нь дур зоргоор хятад иргэдийг элсэн авчирч бэлчээрийг хагалбарласан болхул авчирсан иргэдийн олон цөөнийг үзэж жилийн пүнлүүг торгон хасч, тэрчлэн тус чуулганы даргыг ч адилхан торгомой. Пүнлүү үгүй бусад туслагч тайж буюу сул тайж бол мал, ногоогоор торгомой"⁹ гэсэн зарлигийг нийтэлжээ. Нөгөө талаар хувиараа Монгол газар ирж бэлчээрийг хулгайлан хагалбарласан хятад иргэдийг залхаан шийтгэх тогтоол гаргаж Сайшаал-өрөөлтийн 12 онд: "... хятад иргэдээс дүрэм цаазыг зөрчиж, монгол газрын бэлчээр нутгийг хагалбарласан буюу түрээсэлж тариад хоёр зуун чин хүрсэн болбоос тус иргэнийг далан бэрээ занчин, нэг жил хагасаар хоримой. Тэгэхдээ урьдаар хавтасан хүзүүвч бугуй зүүлгэж, хоёр сар болсны хойно уг нутагт нь хүлж хүргээд хориул дор оруулмой. Гэрээр хагалбарласан бэлчээрийн хэмжээ нь дөчин жинд хүрсэн бөгөөс зуун бэрээ занчиж хавтасан хүзүүвч бугуй зүүлгэж, хоёр сар болсны хойно уг нутагт нь хөөн явуулмой"¹⁰ гэсэн хатуу зарлигийг батлан нийтэлжээ.

Сайшаал-өрөөлтийн үеэс Монгол хийгээд Хятад хоёр талд зориулан нийтэлсэн залхаан шийтгэх дүрэм тогтоолыг урьдахь төрүүдээс нарийн бодитой бөгөөд хатуу чанга байсан юм. Үүний дагуу Чин улсын засгийн газраас бас эл монгол хошууд нь малжилыг нөлөөлөхгүй байдлын дор тус орны жанжин бүгдлэн захирагч хийгээд албан ноёдын зөвшөөрөлтэйгээр сул бэлчээрийн газрыг хошууны албанаас хэмжээтэй хагалбарлан тарихыг дахин зөвшөөрч байжээ.

Эцсийн шат нь Бадаргуулт төрийн 28 он /1902/ оноос Манж чин улс нурах хүртлэх эрин болноо. Хар тамхины дайны дараа гадаадын эзэрхэг түрэмхийтэн ба хөрөнгөт ёсны төржилтөөс болж, Өвөрмонгол орон нь хагас колони хагас феодалын нийгэмд шилжин оржээ. "Цагаагчин үхэр жилийн гэрээ"-нд харийн түрэмгийлэгчдэд их хэмжээний дайны төлбөр төлөх болсон нь Чин улсын засгийн газрыг улс төр ба аж ахуйн хүнд хямралд оруулсан юм. Ийм байдлын дор Манжийн ноёрхогчдоос бүх улсын хэмжээнд "Шинэ засаг" гэдгийг явуулж өдий төдий шинэчлэлийн аргыг хэрэгжүүлж доройтлын байдлыг өөрчлөхөөр оролджээ. Үүний хамт Чин улсын Засгийн газар нь Өвөрмонголд бэлчээр нутгийг бүх талаар нээн хагалбарлаж, газрын үнэ ба түрээс гаалийн мөнгө татварлан хэт аж ахуйн мөлжлөг явуулсан байжээ.

Энэ үед Чин улсын ноёрхогч бүлгийн дотоодод монгол ван ноёдын жолоодсон морьт цэрэг нь шинэ маягийн буу зэвсгээр тоногдсон гадаадын хүчирхэг улсуудын түрэмгийлэл довтоллыг эсэргүүцэн хориглож дийлэхгүй болсон бөгөөд улсын дотоодын тариачны бослогыг ч дарангуйлж чадахгүй байснаас манжийн дарангуйлж чадахгүй байснаас манжийн ноёрхох давхрага дахь Монгол ван ноёдын байр суурь нь илэрхий буурсан байна.

Үүний эсрэгээр гадаадыг дууриаж үйлдвэр уурхай байгуулахад түшиглэн үйлсээн болгосон хятадын нэг бүлэг саргачилсан /дамжин хөдөлгөгч/ газар орны ноёд түшмэд харин манжийн ноёрхох давхрага дотор эрх сүртэн болж бүрэлдээд, Чин улсын ноёрхох бодлогыг тогтоох гол улс төрийн хүчин болсон байна. "Цагаагчин үхэр жилийн гэрээ" тогтоолоор Чин улсаас харийн эзэрхэг түрэмгий улсуудад нийт 400 сая 500 зуун мянган

⁸ "Дайчин улсын Шибо чун хааны магад хууль"-ийн 58 дугаар боть.. Төр гэрэлтийн 3 дугаар оны I сарын харагчин туулай өдрийн зурвас.

⁹ "Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хуулийн хэрэг зүйлийн бичиг" /Сайшаал өрөөлтийн төр/ 742 дугаар боть.

¹⁰ Мөн тэнд.

лан цагаан мөнгө төлөх бөгөөд үүний дээр 39 жилд хуваан төлөх хүү мөнгийг нэмбэл нийт 900 сая 300 мянган лан мөнгөнд хүрчээ.

Чин улс нь гэрээ ёсоор феодал улсын боомтын гаалийн үйлдвэр болон байнгын боомтын гаалийн орлого бүхнээ харийн өрөнд төлбөр болгохоор тогтсон болохоор, тариалангийн гааль нь Чин улсын цорын ганц орлого болсон байна.

Ингээд өнгөрсөнд хэдийгээр цөөхөн бус сайд түшмэд Өвөрмонголын бэлчээр нутгийг цөөн хагалбарлахыг санаачилсан боловч Чин улсын ноёрхогчид ер нь төрийн бодлогын тасархай шийдвэр гаргахгүй байсан бол Бадаргуулт төрийн /27 он/ 1901 онд Шанси мужийн цагдан зохиох сайд Цзин Чүн Сиван урьд хожид хоёр удаа "Монгол хошуудын бэлчээр нутгийг нээн хагалбарлах"-ыг Манжийн төрд гуйчлан айлтгасанд¹¹ Чин улсын засгийн газар "Ашиг орлогыг нэмэгдүүлж" "төлбөр мөнгө цуглуулах"-ийн төлөө өнөөх айлтгалыг зөвшөөрөн баталжээ. Энэ мэтээр Бадаргуулт төрийн 28 он /1902/-д Чин улсын засгийн газар эцсийн шийдвэр гаргаж тэрхүү боомтын доторхи хятад иргэд Монгол оронд ирж бэлчээрийг хагалбарлахыг цаазалж байсан уламжлалт бодлогоо таягдаж Өвөрмонголын баруун хэсгээс эхлэн монгол хошуудын бэлчээр нутгийг бүх талаар нээн хагалбарлах бодлогыг хэрэгжүүлжээ.

Иймээс эцсийн шатанд хэрэгжүүлсэн Чин улсын засгийн газрын бэлчээр нутгийг бүх талаар нээн хагалбарлах төрийн бодлого нь Өвөр Монголын тариалан аж ахуйн мөлжил ба улс төрийн эзэмшлээ чангатгахын төлөө явуулсан нэгэн зүйлийн төрийн бодлого болсон нь илэрхий байна.

¹¹ Шаньси мужийн цагдан зохиох сайд Циун Чүн шиуны айлтгалын бичиг /цахилгаан мэдээгээр илгээсэн бичиг/ Бадаргуулт төрийн 29 оны 4 дүгээр сарын шинийн 9-ний өдөр. "Бээжин дундад улсын 1 дүгээр данс эвхмэл товчооны хадгаламж."